

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 18-ны өдөр

№ 27/02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Монос хүнс” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 28 тоот тогтоол, 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 40% (дөчин хувь)-иар буюу 817,700,856 (найман зуун арван долоон сая долоон зуун мянга найман зуун тавин зургаа) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 2 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохыг Гүйцэтгэх захирал (А.Отгондарь), Ерөнхий нягтлан бодогч (Ц.Дэлгэрмаа) нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих, ногдол ашиг тараах мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Н.Цагаанхүү)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ХУРЛЫН ДАРГА

МОНОС ХҮНС

Х.ДАНАНД

